



ЗАМ ТЭЭВРИЙН САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.20 № 37

Мэдээлэл ирүүлэх тухай

"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан 14 мега төслийн нэгдүгээрт Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын төмөр зам"-ын төсөл эрэмбэлэгдсэн бөгөөд тус төслийн хэрэгжилтийг хангахад зарим хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1.Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан холболтын төмөр замын төслийн явцын талаарх мэдээлэл;

2.Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төмөр замын төсөл хэрэгжсэнээр манай улс хичнээн тонн нүүрсийг экспортлох боломжтой эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

3.Одоогийн байдлаар нүүрс тээвэрлэж байгаа мөн нүүрс тээвэрлэх хүсэлт гаргасан болон тэдгээрээс тусгай зөвшөөрлийг хэрхэн яаж олгож байгаа, олгосон компанийн тоо зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл болно.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж, цаашид Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТАНХУЯГ

